

# “ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/017/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Х.Энхтуяа  
Утас: 89182456 Цахим хаяг: [enkhtuyakh@audit.gov.mn](mailto:enkhtuyakh@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Ахлах аудитор: Г.Заяа  
Утас: 95648028, 98828028  
Цахим хаяг: [zaya96884510@gmail.com](mailto:zaya96884510@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/250  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.МЯГМАРМАА  
ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар нягтлан бодох бүртгэл, төсвийн зарцуулалттай холбоотой дараах материаллаг хэмжээний зөрчил илэрч байна. Үүнд:

1. Туслах үйл ажиллагааны орлогыг хувийн дансаар дамжуулан нягтлан бодох бүртгэлд тусгахгүйгээр байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан, албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнд харгалзахгүй, тушаал шийдвэргүйгээр олгосон, цалин, амралтын мөнгийг давхардуулан олгосон зэрэг нийт 14,735.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.1, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35/А/10/ 1 тушаалаар батлагдсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" журмын 3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг тус тус зөрчсөн ба тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
2. Сургуулийн дотуур байрны гал тогоонд батлагдсан норм, стандартаас 2 тогооч илүү ажиллуулан 37,872.0 мянган төгрөгөөр цалинжуулан төсвийн үр ашгийг бууруулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16

дугаар зүйлийн 16.5.3, "Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ" Ерөнхий шаардлага MNS 6781-2019 стандартын 7.7 заалтыг тус тус зөрчсөн, "эрх үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд улсын төсвөөс олгох санхүүжилтийг 69,556.6 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлснээс гадна орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг 73,829.8 мянган төгрөгөөр хасаж тодотгол хийсэнтэй холбоотой 112,532.2 мянган төгрөгийн түлш, халаалтын өр үүссэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар бараа материалын тайлагналтай холбоотой нийт 33,026.1 мянган төгрөгийн зөрчилд холбогдох шийдвэрийг гаргасан болно

#### **Бусад асуудлын хэсэг**

Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 38 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 90 хувьтай тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан</i>		<i>/төгрөгөөр/</i>
Балансын үзүүлэлт	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>552,116,768.79</b>	<b>431,804,064.77</b>
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>245,999,613.79</b>	<b>143,260,596.94</b>
Банкинд байгаа бэлэн мөнгө	245,999,613.79	143,260,596.94
Төгрөг	245,999,613.79	143,260,596.94
Төрийн сангийн харилцах	245,999,613.79	143,260,596.94
АВЛАГА	1,481,578.43	99,000.00
Ажиллагсадтай холбогдсон авлага	1,481,578.43	99,000.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>304,635,576.57</b>	<b>288,444,467.83</b>
Түүхий эд материал	180,720,985.78	180,720,985.78
Тусгай зориулалттай материал	180,386,115.78	180,386,115.78
Эм боох материал	334,870.00	334,870.00
Хангамжийн материал	116,384,590.79	98,853,482.05
Бичиг хэргийн материал	8,250,787.00	58,400.00
Аж ахуйн материал	20,780,215.00	20,780,215.00
Хүнсний материал	32,354,817.69	19,077,734.69
Бусад хангамжийн материал	54,998,771.10	58,937,132.36
Мал, амьтад	7,530,000.00	8,870,000.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,973,810,194.21</b>	<b>3,971,352,717.25</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,973,810,194.21</b>	<b>3,971,352,717.25</b>
Биет хөрөнгө	3,818,661,194.21	3,818,948,717.25
Барилга, байгууламж	3,929,255,889.90	4,014,255,889.90
Хуримтлагдсан элэгдэл	-701,168,276.68	-831,846,323.38
Авто тээврийн хэрэгсэл	79,800,000.00	79,800,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-	-13,299,999.96
Машин, тоног төхөөрөмж	435,193,431.68	486,649,417.08
Хуримтлагдсан элэгдэл	-148,450,973.11	-194,089,990.79
Тавилга, аж ахуйн эд хогшил	100,239,690.39	170,701,829.20
Хуримтлагдсан элэгдэл	-54,631,534.45	-59,016,761.96
Бусад үндсэн хөрөнгө	229,152,669.50	229,152,669.50
Хуримтлагдсан элэгдэл	-98,435,930.92	-113,691,328.88
Номын фонд	47,706,227.90	50,333,316.54
Биет бус хөрөнгө	155,149,000.00	152,404,000.00
Програм хангамж	9,306,500.00	9,306,500.00
Хасагдуулга	-581,500.00	-3,326,500.00
Бусад биет бус хөрөнгө	146,424,000.00	146,424,000.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,525,926,963.00</b>	<b>4,403,156,782.02</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>146,290,447.76</b>	<b>159,297,526.48</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>146,290,447.76</b>	<b>159,297,526.48</b>
Өглөг	146,290,447.76	159,297,526.48
Бараа үйлчилгээний зардлын өглөг	60,282,447.76	114,254,928.48
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	63,747,700.00	42,498,448.00
Бусад өглөг	22,260,300.00	2,544,150.00
Байгууллагад төлөх өглөг	22,260,300.00	2,544,150.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,379,636,515.24</b>	<b>4,243,859,255.54</b>
Засгийн газрын хувь оролцоо	4,379,636,515.24	4,243,859,255.54

Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	548,092,734.40	548,092,734.40
Өмч: -Төрийн өмч	548,092,734.40	548,092,734.40
Хуримтлагдсан үр дүн	2,410,882,331.81	2,275,105,072.11
Өмнөх үеийн үр дүн	2,410,882,331.81	2,410,882,331.81
Тайлант үеийн үр дүн	-	-135,777,259.70
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,420,661,449.03	1,420,661,449.03
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,525,926,963.00</b>	<b>4,403,156,782.02</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

### Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,855,021,098.30</b>	<b>3,241,809,977.15</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>204,084,298.30</b>	<b>231,540,077.15</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>204,084,298.30</b>	<b>231,540,077.15</b>
Төсөвт байгууллагын өөрийн орлого	204,084,298.30	4,744,700.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	676,293.00	4,744,700.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,722,600.00	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	185,685,405.30	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ	-	220,292,015.89
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ	-	6,503,361.26
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,650,936,800.00</b>	<b>3,010,269,900.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,319,005,800.00</b>	<b>2,678,441,700.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,319,005,800.00	2,678,441,700.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>331,931,000.00</b>	<b>331,828,200.00</b>
<b>Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/</b>	<b>331,931,000.00</b>	<b>331,828,200.00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>2,846,537,763.23</b>	<b>3,377,587,236.85</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,846,537,763.23</b>	<b>3,377,587,236.85</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,780,127,173.58</b>	<b>3,298,974,526.85</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,736,371,137.66</b>	<b>2,196,629,721.12</b>
Цалин	1,141,129,498.34	1,325,090,555.28
Нэмэгдэл цалин	520,494,919.32	738,692,545.94
Унаа хоолны хөнгөлөлт	-	69,567,366.40
Урамшуулал	74,746,720.00	63,279,253.50
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>222,558,200.31</b>	<b>267,576,933.81</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	150,819,526.35	181,651,068.85
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	18,526,580.73	21,488,172.05
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9,487,132.00	11,123,199.34
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	8,744,992.33	10,673,616.41
Эрүүл мэндийн даатгалын хураамж	34,979,968.90	42,640,877.16
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>379,213,447.76</b>	<b>375,800,680.72</b>

Гэрэл цахилгааны зардал	15,987,331.76	15,774,564.72
Түлш, халаалтын зардал	361,326,116.00	360,026,116.00
Цэвэр, бохир усны зардал	1,900,000.00	-
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,614,130.50</b>	<b>38,303,787.00</b>
Бичиг хэргийн материал	1,242,980.00	21,598,687.00
Тээвэр, шатахууны зардал	10,482,550.50	10,715,300.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	8,568,600.00	5,989,800.00
Бараа материал актасны зардал	7,320,000.00	-
<b>Нормативт зардал</b>	<b>125,973,184.56</b>	<b>142,908,693.00</b>
Хоол	125,973,184.56	142,908,693.00
Эд хогшил, урсгал засварын зардал	15,700,000.00	10,000,000.00
Урсгал засвар	15,700,000.00	10,000,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>14,105,664.31</b>	<b>25,607,018.35</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,657,200.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	14,105,664.31	20,949,818.35
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>258,591,408.48</b>	<b>242,147,692.85</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	36,865,650.00	12,598,200.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	16,594,500.00	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	205,131,258.48	229,549,492.85
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>66,410,589.65</b>	<b>78,612,710.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>66,410,589.65</b>	<b>78,612,710.00</b>
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,717,055.65	78,612,710.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	6,693,534.00	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>8,483,335.07</b>	<b>(135,777,259.7)</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>8,483,335.07</b>	<b>(135,777,259.7)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	548,092,734.40	1,420,661,449.03	2,410,882,331.81	4,379,636,515.24
2	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	(135,777,259.70)	(135,777,259.70)
3	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	548,092,734.40	1,420,661,449.03	2,275,105,072.11	4,243,859,255.54

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,669,052,800.00</b>	<b>3,015,014,600.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,116,000.00</b>	<b>4,744,700.00</b>
Нийтлэг татварын бус орлого	18,116,000.00	4,744,700.00
<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>18,116,000.00</b>	<b>4,744,700.00</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	393,400.00	4,744,700.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,722,600.00	-
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,650,936,800.00</b>	<b>3,010,269,900.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,319,005,800.00</b>	<b>2,678,441,700.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,319,005,800.00	2,678,441,700.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>331,931,000.00</b>	<b>331,828,200.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	331,931,000.00	331,828,200.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>2,616,012,290.91</b>	<b>3,110,953,616.85</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,616,012,290.91</b>	<b>3,110,953,616.85</b>
<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,548,546,730.91</b>	<b>3,043,791,556.85</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,746,565,330.69	2,195,247,142.66
Үндсэн цалин	1,161,002,536.82	1,323,707,976.82
Нэмэгдэл	511,958,717.87	738,692,545.94
Унаа хоолны хөнгөлөлт	-	69,567,366.40
Үр дүнгийн урамшуулал	73,604,076.00	63,279,253.50
<b>Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>212,783,355.41</b>	<b>267,576,933.84</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	143,810,893.60	181,651,068.85
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	16,676,045.39	21,488,172.05
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9,695,706.42	11,123,199.34
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	9,234,937.99	10,673,616.41
Эрүүл мэндийн даатгалын хураамж	33,365,772.01	42,640,877.19
<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>321,931,000.00</b>	<b>321,828,200.00</b>
Гэрэл цахилгааны зардал	13,077,847.67	14,051,848.12
Түлш, халаалтын зардал	304,043,668.24	307,776,351.88
Цэвэр, бохир усны зардал	4,809,484.09	-
<b>Нормативт зардал</b>	<b>116,279,750.00</b>	<b>136,926,260.00</b>
Хоол, хүнс	116,279,750.00	136,926,260.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,000,000.00</b>	<b>10,000,000.00</b>
Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,838,164.31</b>	<b>25,757,018.35</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	539,400.00	4,657,200.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,298,764.31	21,099,818.35

<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>126,149,130.50</b>	<b>86,456,002.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	111,600,030.50	76,214,602.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	14,549,100.00	10,241,400.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>67,465,560.00</b>	<b>67,162,060.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>67,465,560.00</b>	<b>67,162,060.00</b>
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	59,756,100.00	67,162,060.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	7,709,460.00	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>53,040,509.09</b>	<b>(95,939,016.85)</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>33,892,850.00</b>	<b>6,800,000.00</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>33,892,850.00</b>	<b>6,800,000.00</b>
Дотоод эх үүсвэрээр	33,892,850.00	6,800,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,892,850.00	6,800,000.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(33,892,850)</b>	<b>(6,800,000.00)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>19,147,659.09</b>	<b>(102,739,016.85)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	226,851,954.20	245,999,613.79
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	245,999,613.29	143,260,596.94

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 5. төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	3,322,757,400.00	3,015,014,600.00	307,742,800.00	90.74
УЛСЫН ТӨСВӨӨС	2,747,998,300.00	2,678,441,700.00	69,556,600.00	97.47
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС	331,828,200.00	331,828,200.00	-	100.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	8,775,300.00	4,744,700.00	4,030,600.00	54.07
Туслах үйл ажиллагааны орлого	87,500.00	-	87,500.00	-
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	234,068,100.00	-	234,068,100.00	-

<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,322,757,400.00</b>	<b>3,015,014,600.00</b>		
Ажиллагчидтай холбогдсон зардал				
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,322,757,400.00</b>	<b>3,117,753,616.85</b>	<b>205,003,783.15</b>	<b>93.83</b>
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,322,757,400.00	3,117,753,616.85	205,003,783.15	93.83
Бараа, үйлчилгээний зардал	3,245,300,900.00	3,050,591,556.85	194,709,343.15	94.00
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,325,239,200.00</b>	<b>2,195,247,142.66</b>	<b>129,992,057.34</b>	<b>94.41</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,443,055,300.00	1,317,309,659.31	125,745,640.69	91.29
Цалингийн тусгай нэмэгдлүүд	882,183,900.00	877,937,483.35	75,983,836.55	90.75
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>290,981,900.00</b>	<b>267,576,933.84</b>	<b>23,404,966.16</b>	<b>91.96</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	244,424,800.00	181,651,068.85	16,216,831.15	91.80
Эрүүл мэндийн даатгалын хураамж	46,557,100.00	42,901,691.14	3,655,408.86	92.15
<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	<b>384,708,100.00</b>	<b>333,101,340.35</b>		
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	321,828,200.00	321,828,200.00	-	100.00
Гэрэл цахилгаан	13,000,000.00	14,051,848.12	-1,051,848.12	108.09
Түлш, халаалт	306,828,200.00	307,776,351.88	-948,151.88	100.31
Цэвэр, бохир ус	2,000,000.00	-	2,000,000.00	-
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	384,708,100.00	333,101,340.35		
Хоол, хүнс	165,355,000.00	136,926,260.00	28,428,740.00	82.81
Бараа үйлчилгээний бусад зардал	86,172,600.00	83,014,602.00	3,157,998.00	96.34
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,274,600.00	10,241,400.00	33,200.00	99.68
Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,195,400.00	4,657,200.00	1,538,200.00	75.17

Мэдээллийн технологийн зардал	29,254,000.00	21,099,818.35	8,154,181.65	72.13
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	77,456,500.00	67,162,060.00	10,294,440.00	86.71
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>3,322,757,400.00</b>	<b>3,117,753,616.85</b>	<b>205,003,783.15</b>	<b>93.83</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	245,999,613.79		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	143,260,596.94		-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 238,709.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 238,709.0 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн үлдэгдлийг 8,582.5 мянган төгрөгөөр, бараа материалын үлдэгдлийг 170.0 мянган төгрөгөөр, хуримтлагдсан элэгдлийн үлдэгдлийг 2,745.0 мянган төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 226,795.4 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 330.0 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг 87.5 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “ерөнхий нягтлан бодогч .холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана” гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 773,742.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,047.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 10,634.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 758,060.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

#### 3.1 Төлбөрийн акт

1. Нэр бүхий 2 ажилтанд 2,577.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг холбогдох журмаас илүү тооцож олгосон, 1 ажилтанд 1,023.0 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой, давхардуулан олгосон, туслах үйл ажиллагааны 946.5 мянган төгрөгийн орлогыг тайлант хугацаанд бүрэн төвлөрүүлээгүй, тус орлогоос 500.0 мянган төгрөгийг тэмцээн уралдааны эрхийн төлбөрт зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3-т “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.8-т “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно”, гэж заасныг тус тус зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### 3.2 Албан шаардлага

1. Сургуулийн гал тогоо, үдийн цайны тогоочийг ашиглан, багш ажилчдад үдийн хоолны үйлчилгээ үзүүлж олсон орлого, сурагчдын зуны даалгаврын мөнгөн төлбөр, түрээсийн төлбөр зэргээс бүрдсэн нийт 10,634.5 мянган төгрөгийн орлогыг сургуулийн дансанд төвлөрүүлэлгүйгээр, сургуулийн захирал хувийн дансандаа авч байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан, зарцуулсан, тайлангаа хамт олондоо нээлттэй мэдээлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 44.1.1-д “Төсвийн байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр, эсхүл энэ хуулийн 35.4-т заасан цахим хэлбэрээр зөвшөөрсөн тохиолдолд туслах үйл ажиллагаа явуулж, орлого олж болно”: 44.1.3-д санхүүгийн тайлан болон үр дүнгийн гэрээнд уг үйл ажиллагааны талаар зохих ёсоор тусгасан байх; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, .17 дугаар зүйлийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно”, гэж заасныг тус тус зөрчсөн байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Төсвийн гүйцэтгэл, тайлагналтай холбоотой асуудал:**

##### Илрүүлэлт:

1. Сургуулийн хоол үйлдвэрлэлд стандартад заагдсанаас 2 тогооч илүү ажиллуулан 37,872.0 мянган төгрөгийг цалинд олгосон нь "Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ" Ерөнхий шаардлага MNS 6781-2019 стандартыг зөрчсөн, ба “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

1. Сургуулийн хоол үйлдвэрлэлд стандартад заагдсанаас 2 тогооч илүү ажиллуулсан зөрчлийг арилгах, “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ” Ерөнхий шаардлага MNS 6781-2019 стандартыг мөрдөж ажиллах,

#### **Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

1. Эд хариуцагч нь тайлант оны бараа материалын тайланг сар бүрийн эцэст гаргаагүй, 33,026.1 мянган төгрөгийн бараа материалын тайланг 5 сарын дараа нэгтгэн гаргасан, нягтлан бодогч нь шалгаж тооцоо бодоогүй байна. Энэ нь тус сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөөгүй, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна

##### Өгсөн зөвлөмж:

1. Эд хариуцагчид бараа материалын тайланг тус сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн

материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргаж хэвших үүргийг хүргүүлэн, үр дүнг хянах;

**Нийцлийн аудиттай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

1. Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 576,484.8 мянган төгрөгөөр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг 110,677.9 мянган төгрөгөөр тус тус дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.4.4-д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

1. Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Хүснэгт 6. Завсрын аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	103,541.6			1	103,541.6	1	103,541.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>103,541.6</b>			<b>1</b>	<b>103,541.6</b>	<b>1</b>	<b>103,541.6</b>				

**Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	238,709.0			1	238,709.0	1	238,709.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>238,709.0</b>			<b>1</b>	<b>238,709.0</b>	<b>1</b>	<b>238,709.0</b>				

**Хүснэгт 8. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сургуулийн хоол үйлдвэрлэлд стандартад заагдсанаас 2 тогооч илүү ажиллуулан	1	37,872.0					1	37,872.0
Эд хариуцагч нь тайлант оны бараа материалын тайланг хугацаанд нь гаргаагүй	1	33,026.1					1	33,026.1
Нэр бүхий ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг холбогдох журмаас илүү тооцож олгосон, цалинг ээлжийн амралтын олговортой, давхардуулан олгосон,	1	3,600.8	1	3,600.8				
туслах үйл ажиллагааны орлогыг тайлант хугацаанд бүрэн төвлөрүүлээгүй	1	946.5	1	946.5				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>75,445.4</b>	<b>2</b>	<b>4,547.3</b>			<b>2</b>	<b>70,898.1</b>

**Хүснэгт 9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илэрсэн.								
Шилэн дансанд мэдээллийн мөнгөн дүнг үнэн зөв байршуулаагүй	1	687,162.7					1	687,162.7
Туслах үйл ажиллагааны орлогыг сургуулийн дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан	1	10,634.5			1	10,634.5		
Туслах үйл ажиллагааны орлогоос 500.0 мянган төгрөгийг тэмцээн уралдааны эрхийн төлбөрт зарцуулсан байна.	1	500.0	1	500.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>698,296.5</b>	<b>1</b>	<b>500.0</b>	<b>1</b>	<b>10,634.5</b>	<b>1</b>	<b>687,162.7</b>